



АЗИЙН ХӨГЖЛИЙН
БАНК



ЕВРОПЫН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН БАНК



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Улаанбаатар

ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

●ТӨСӨЛ 1-ИЙН 2017 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ 2018.02.01




ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР


2013 ОН

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийг санхүүжүүлэхээр МУ-ын Засгийн газар болон Азийн Хөгжлийн Банк хооронд хэлэлцээр хийсэн.



2014 ОН

Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг 2014 оны 05 дугаар сарын 23-ны өдөр МУ-ын УИХ-аар соёрхон баталсан.



2030 ОН

хүртэлх хөгжлийн чиг хандлага баримт бичигт

2020 ОН

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотголд

эдийн засгийн боломж, орон сууц, хотын дэд бүтцийн үйлчилгээ хангамж бүхий эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлэхээр заасан.

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага баримт бичигт заасан эдийн засгийн боломж, орон сууц, хотын дэд бүтцийн үйлчилгээ хангамж бүхий эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлсэн, бие даан хөгжсөн дэд төвийн сүлжээг гэр хороололд бий болгох зорилтыг хэрэгжүүлэхтэй уялдуулан “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийг санхүүжүүлэхээр МУ-ын Засгийн газар болон Азийн Хөгжлийн Банк хооронд 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг 2014 оны 05 дугаар сарын 23-ны өдөр МУ-ын УИХ-аар соёрхон баталсан.

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хотын "Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" нь 3 үе шаттайгаар хэрэгжих ба хөтөлбөрийн 1 дүгээр үе шат болох Төсөл-1-ийн санхүүжилтийн 51.38 хувийг Азийн хөгжлийн банк, 27.15 хувийг Европын хөрөнгө оруулалтын банк, үлдсэн 21.45 хувийг Нийслэлийн төсвөөс бүрдүүлж байна. Төсөл-1-ийг 2014 оны 05 дугаар сарын 23-ны өдөр УИХ-аар соёрхон баталсан.

Хөтөлбөрийн хүрээнд 6 дэд төвийн дэд бүтцийн суурийг тавих бөгөөд Төсөл-1-ийн хүрээнд Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийн суурийг тавьж, улмаар нийслэлийн хойд бүсийн хүн амд үйлчилдэг, худалдаа, соёлын үйлчилгээний төвлөрөл бүхий авто зам, дулаан, цэвэр ус, цахилгаан хангамж болон ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээ, хүүхдийн цэцэрлэг, бизнес инкубатор төвтэй, агаарын болон хөрсний бохирдолгүй, байгаль орчинд ээлтэй, ногоон орчинг бүрдүүлсэн, эдийн засаг, соёл, нийгмийн үйлчилгээний идэвхтэй бүс болгоно.



ХӨТӨЛБӨРИЙН НИЙГМИЙН АЧ ХОЛБОГДОЛ:

УЛААНБААТАРЫН УТАА, ХӨРСНЫ БОХИРДОЛ БАГАСНА

- Баянхошуу, Сэлбэ төв нь Улаанбаатар хотын агаарын урсгалын дээр байрладаг бөгөөд хөтөлбөр хэрэгжсэнээр зөвхөн Сэлбэ төвийн нүүрсний хэрэглээ 15,000 тонноор буурч, агаарын бохирдол багасаж, төслийн үр шимийг Улаанбаатар хотын 1.4 сая иргэн хүртэнэ.

10 МЯНГАН НОГООН ОРОН СУУЦ БАРИГДАНА

- Улаанбаатар хотын дэд төвүүдэд иргэдийн газрыг орон сууцаар шууд солих нөхцөлтэй 10 мянган ногоон орон сууц төслийг Нийслэлийн Засаг даргын тамгын газар хариуцан, Азийн хөгжлийн банк санхүүжүүлэн хэрэгжүүлнэ.

ХОТЫН ТӨВИЙН АЧААЛАЛ БУУРНА

- Тухайн дэд төвүүдэд шинээр байгуулагдах үйлдвэр, үйлчилгээний байгууллагуудад иргэд ажил эрхлэх боломж бий болох зэрэг таатай нөхцөл бүрдэж хотын "зах"–аас хотын төв рүү ирэх ачаалал буурна.

ДЭД БҮТЦИЙН СҮЛЖЭЭ ӨРГӨЖНӨ

- Дэд төвүүдийн хэсэгт явган болон авто замын бүтээн байгуулалт, цэвэр болон бохир усны дэд бүтэц хийгдсэнээр иргэд дээрх үйлчилгээнүүдийг хүртэх боломжтой болно.


АЖЛЫН БАЙР ШИНЭЭР БИЙ БОЛНО

- Бүтээн байгуулалтын ажлын үед иргэд олон нийт, амьжиргааны түвшин доогуур иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд)-эд мэргэжлийн чиг баримжаа олгох замаар хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлнэ.

ТАВ ТУХТАЙ, АЮУЛГҮЙ ОРЧИН БИЙ БОЛНО

- Гудамжны гэрэлтүүлэг болон явган хүний зорчих орчинг бүрэн бүрэлдүүлсэн авто зам, олон нийтийн амралт зугаалгын ногоон байгууламж бий болсноор тав тухтай орчин бий болно.

ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮДҮҮВЧ



"Баянхошуу дэд төв"-ийн түр суурьшуулах 50 айлын орон сууц



"Сэлбэ дэд төв"-д барих Дулааны станцын шав тавих ёслолын үйл ажиллагаа



"Сэлбэ дэд төв"-ийн түр суурьшуулах 50 айлын орон сууц




Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ



САНХҮҮЖИЛТИЙН ХУВЬ



САНХҮҮЖИЛТ ТАЙЛАН

УБ хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр нь нийт 320 сая ам.долларын санхүүжилттэйгээр 3 үе шаттайгаар хэрэгжинэ. Тус хөтөлбөр нь зорилтот дэд төвүүдэд инженерийн үндсэн гол шугам сүлжээ, нийгмийн байгууламжуудыг барьж ашиглалтад оруулах ба хот төлөвлөлтийн шинэчлэл, хот байгуулалтын чадавх бэхжүүлэх зөвлөх үйлчилгээний хүрээнд дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг иргэдийн оролцоотой шинэчлэн боловсруулах, дэд төвийг хөгжүүлэх цогц төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх суурь нөхцлийг бүрдүүлэх замаар шинэ дэд төвийг эдийн засаг, соёл, нийгмийн үйлчилгээний идэвхтэй бүс болгох зарчимд тулгуурласан. Хөтөлбөрийн үе шат бүр энэ зарчмын дагуу төлөвлөгдсөн ба бүтээн байгуулалтаар бий болсон дэд бүтцийн үр ашигтай байдал нь зөвлөх үйлчилгээний хүрээнд бий болох дэд төвийн хөгжлийн цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй нягт уялдаатай.

Төсөл нь нийт 104.5 сая ам.долларын санхүүжилттэй

ба үүний 53.7 сая ам.доллар буюу 51.38%-ийг АХБ, 28.38 сая ам.доллар буюу 27.15%-ийг ЕХОБ, үлдсэн 22.42 сая ам.доллар буюу 21.45%-ийг Нийслэлийн төсвөөс санхүүжүүлнэ.

АХБ-ны дунд шатны үнэлгээний баг 2017 оны 2 дугаар сард 2 долоо хоногийн хугацаатай ажилласан. Дунд шатны үнэлгээний явцад ТХН-ээс хяналт шинжилгээ үнэлгээний тайланг танилцуулсан. Тайлангийн хугацаанд АХБ-ны удирдах зөвлөлийн гишүүд, Ази номхон далайн бүсийг хариуцсан ерөнхий захирал зэрэг албаны хүмүүс нийт 4 удаагийн ажлын айлчлал хийж, төслийн явцтай танилцан санал, зөвлөмж өгч ажиллав.

"Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр"-ийн санхүүжилт нь Азийн хөгжлийн банкны /АХБ/-ны дүрэм журмын дагуу явагддаг бөгөөд бүхий л шатны хяналт шалгалт, жилийн эцсийн санхүүгийн тайланг АХБ-ны журмын дагуу шат, шатны аудитын байгууллага хянан шалгадаг.



500.000\$-ЫН

БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ШИЙДВЭРЛҮҮЛЭЭ

Төсөл хэрэгжүүлэх нэгжээс санаачлан санал боловсруулж, АХБ-ны холбогдох хүмүүстэй хамтран ажилласнаар энэхүү нэмэлт санхүүжилтийг буцалтгүй тусламжаар авах болов. Дэд төвийн мэдээллийн цахим систем бий болсноор дэд төвийн нэгжийн талаарх аливаа шийдвэрийг тоо баримт, бодит мэдээлэлд тулгуурлан гаргах нөхцөл бүрдэнэ.



АХБ 2017 оны 09 дүгээр сард 500,000 ам.долларын буцалтгүй тусламж үзүүлэх санамж бичигт гарын үсэг зурсан. Уг тусламжаар мониторинг болон мэдээллийн цахим систем бий болж дэд төвийн иргэд үр ашгийг нь хүртэнэ.

ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЗАДАРГАА

2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд АХБ-ны журмын дагуу Үндэсний Аудитын газраас Санхүүгийн тайлангийн аудит хийсэн ба аудитын ажлын явцад аудитын байгууллагаас шаардсан бүхий л баримтматериалуудыг гарган өгч, холбогдох асуултуудад тайлбар өгч аудитыг дуусгавар болгосон. Аудитын тайлан эерэг дүгнэлттэй гарсан байна.

НЗДТГ-ын Дотоод аудитын албанаас төслийн 2014, 2015, 2016 оны Хөрөнгө оруулалтын дансуудын хүрээнд гүйцэтгэлийн аудит хийсэн.


ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын хэлтсээс аудит хийсэн.

Нийслэл дэх Төрийн Аудитын Газраас НЗДТГ-ын барьцаа хөрөнгийн дансанд гүйцэтгэлийн аудит хийсэн ба зөрчилгүй санал дүгнэлт гарсан.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР	САНХҮҮЖИЛТ	ЗАРЦУУЛАЛТ				
		2014	2015	2016	2017	НИЙТ
ADB OCR Зээл No. 3098-MON	27,500,000.00	8,708.33	47,621.20	55,216.83	66,179.35	177,725.71
ADB ADF Зээл No. 3099-MON	19,780,000.00		1,086,749.87	3,695,393.15	1,570,019.31	6,352,162.33
ADB UEIF Буцалтгүй тусламж No.0380-MON	3,700,000.00	-			2,059,022.70	2,059,022.70
Европийн Хөрөнгө Оруулалтын Банк (EIB)	22,010,000.00	-	-	1,759,315.00	392,738.03	2,152,053.03
Хэсгийн дүн /ам.доллар/	72,990,000.00	8,708.33	1,134,371.07	5,509,924.98	4,087,959.39	10,740,963.78
МУ-ын ЗГ НЗДТГ /Төгрөг/				1,142,185,770.00	3,603,011,353.00	14,719,012,625.28
Хэсгийн дүн /ам.доллар/	33,150,000.00			458,795.74	2,144,832.74	2,603,628.49
НИЙТ ДҮН /ам.доллар/	106,140,000.00	8,708.33	1,134,371.07	5,968,720.72	6,232,792.13	13,344,592.26

Эх суралж: www.ub-subcenter.mn

ТӨСЛИЙН МЕНЕЖМЕНТ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦОО



ОРОЛЦОГЧ ТАЛУУД ГЭЖ ХЭН БЭ?

ХӨТӨЛБӨРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫГ ДООРХИ ОРОЛЦОГЧ ТАЛУУД ХАРИУЦДАГ



Азийн Хөгжлийн Банк (АХБ):

Хөтөлбөрийн хэрэгжилт, үүний дотор хариуцагч болон хэрэгжүүлэгч байгууллагууд хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой үүрэг, хариуцлагаа АХБ-ны бодлого, журамд хэрхэн нийцүүлэн хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавина.



Засгийн газар: (Сангийн яам)

АХБ-ны зүгээс хүлээн авахуйц арилжааны банкинд төслийн 5 тусгай данс (зээлийн ба буцалтгүй тусламжийн эх үүсвэр тус бүрээр)-ыг нээх; Төслийн санхүүд жил бүр Аудитын хяналтыг оруулахыг хариуцна Төслийн ба зээлийн гэрээний хэлэлцээр хийнэ.

Төсөл удирдах хороо

Улаанбаатар хотын Засаг дарга ахална.

Бүрэлдэхүүнд нь Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Хөдөлмөрийн яам, Боловсролын яам, шаардлагатай тохиолдолд холбогдох агентлагуудын төлөөлөл орно. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн явцад хяналт тавина.



Улаанбаатар хотын захиргаа (НЗДТГ) Гүйцэтгэх байгууллага

Хөтөлбөрийн ерөнхий хяналт, захиргааны чиг үүргийг хэрэгжүүлнэ. Олон талт зохицуулалтын хороог байгуулж, үйл ажиллагааны хөтөлбөрийг мөрдөж ажиллана. Хөрөнгө оруулалтын хөтөлбөр, замын зураг-төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавина.



Улаанбаатар хотын захиргаа (НЗДТГ) Хэрэгжүүлэх байгууллага –

Хөтөлбөрийн хэрэгжилт, үүний дотор санхүү, захиргаа, техникийн болон худалдан авалтын асуудлууд, хяналт шинжилгээ үнэлгээ, хамгааллын арга хэмжээний хэрэгжилтийг хариуцна.



Европын хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ):

Хөтөлбөрийн хэрэгжилт, ялангуяа усны салбарт хийгдэж буй ажлуудад хяналт тавина.

Төсөл хэрэгжүүлэх нэгж



Хөтөлбөрийн хэрэгжилт, менежментийн асуудлыг хариуцна. Хөтөлбөрийн гүйцэтгэл, менежментийн системийг боловсруулж төлөвшүүлнэ.

Хөтөлбөрийн бүх дэд бүрэлдэхүүн хэсгүүдийн нарийвчилсан хэмжилт, судалгаа, инженерийн зураг төслийг хариуцана.

Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахын зэрэгцээ нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний эцсийн хувилбар, байгаль орчны менежментийн шинэчилсэн төлөвлөгөөг боловсруулж/шинэчилж АХБ-наас зөвшөөрөл авахаар хүргүүлэх, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, байгаль орчны болон нийгмийн хамгааллын арга хэмжээтэй холбоотой шаардлагатай бүх баримт бичгүүдийг хэрэгжүүлнэ.

Тендер зарлахаас өмнө барилгын бүх ажлуудын техникийн болон экологийн экспертизийн дүгнэлт гаргуулна.


Барилгын ажил, материал тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлт, зөвлөх үйлчилгээний гэрээний худалдан авалт, менежментийг (хотын захиргааны холбогдох байгууллагуудын дэмжлэгтэйгээр) хэрэгжүүлэхэд нь Улаанбаатар хотын захиргаанд дэмжлэг үзүүлнэ. Барилгын ажлын гүйцэтгэлийн хяналт шинжилгээ, чанарын хяналтыг хамгааллын арга хэмжээний хэрэгжилтийн хамт хангуулна.

Санхүүжилтийн зарцуулалт, үүний дотор мөнгөн хүсэлтийн өргөдөл, дансны зузаатгал хийх өргөдөл бэлтгэх, улмаар Улаанбаатар хотын захиргаа болон Сангийн яамаар батлуулахтай холбоотой асуудлаар АХБ болон ЕХОБ-тай харьцаж зохицуулалт хийх, холбогдох дагалдах баримтуудыг бүрдүүлж хадгална. Явцын тайлан болон аудитын тайлангуудыг АХБ, ЕХОБ болон Улаанбаатар хотын захиргаанд хугацаанд нь хүргүүлнэ.

ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ



ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ, ХЯНАЛТЫН СХЕМ



Төслийн ХАА- АХБ, ЕХОБ-ны журмын дагуу явуулдаг тул ХАА-нд оролцогч байгууллагуудын боловсон хүчний чадавхаас шалтгаалж тендерийн үнэлгээний явцад хугацаа алдах эрсдэлтэй

Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/180 тоот захирамжийн дагуу Төслийн худалдан авах ажиллагааны эрх Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжсэн. Дотоодын аж ахуйн нэгжүүдэд өрсөлдөх боломж олгох чиглэлийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас баримталж байгаа боловч энэ нь худалдан авах ажиллагааны хугацааг уртасгах, олон шат дамжлагатай болгосон. Мөн худалдан авах ажиллагаанд процедурын алдаа гарах магадлалыг нэмэгдүүлж, тендерт оролцогчдод ойлгомжгүй нөхцөл байдал үүсгэсэн зэрэг асуудлууд гарсан. Улмаар Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2017 онд Төслийн худалдан авах ажиллагааны нийт 18 тендер зарласнаас үнэлгээний тайлан эцэслэгдээгүй 1, шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул бүх тендерээс татгалзсан 2 тохиолдол байна.

ШИЙДЭЛ:

Худалдан авах ажиллагааг төслийн удирдлагын баримт бичигт заасны дагуу 2017 оны 10 дугаар сараас ТХН-д хариуцуулахаар болсон.

ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ 2017 ОНД



ТӨСЛИЙН 1-Р ҮЕ ШАТАНД БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ТРАССЫН ДАГУУ ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТ, НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТЭД ӨРТСӨН НЭГЖ ТАЛБАРЫН ТОО (ДЭД ТӨВ ТУС БҮРЭЭР)

01

**БАЯНХОШУУ-АВТО ЗАМ,
ШУГАМ СҮЛЖЭЭ
БАЯНХОШУУ-ЦЭЦЭРЛЭГ, МСҮТ**

Нөлөөлөлд өртөгсөд /2017.12.28/

Нэгж талбар	хагас	бүтэн
350	226	124
27		27

02

**СЭЛБЭ -АВТО ЗАМ, ШУГАМ СҮЛЖЭЭ
СЭЛБЭ ЦЭЦЭРЛЭГ, МСҮТ,
ДУЛААНЫ СТАНЦ**

Нөлөөлөлд өртөгсөд /2017.12.28/

Нэгж талбар	хагас	бүтэн
350	211	139
42		42

03

**КТМС-ТАЛХ ЧИХЭР ХҮРТЭЛХ
ЦЭВЭР УСНЫ ШУГАМ**

Нөлөөлөлд өртөгсөд /2017.12.28/

Нэгж талбар	хагас	бүтэн
15	13	2

04

**БАЯНХОШУУ
УСАН САН**

Нөлөөлөлд өртөгсөд /2017.12.28/

Нэгж талбар	хагас	бүтэн
11	3	8



Нийт

Нэгж талбар хагас бүтэн
795 453 342

ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТ, НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ

Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажиллагаа Төслийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн дагуу АХБ-ны Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн бодлого, зарчмын дагуу зохион байгуулах үүргийг МУ-ын Засгийн газар хүлээсэн ба үүнд холбогдох бүх зардлыг Нийслэлийн төсвөөс гаргана. Баянхошуу, Сэлбэ дэд төвд баригдах ариутгах татуургын гол шугамын барилга угсралтын ажлын газар чөлөөлөлтийн төлөвлөгөөг 100% хэрэгжүүлсэн, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц 2017 оны эцсийн байдлаар 70 хувьд хүрээд байна.

Нөлөөлөлд өртсөн нэгж талбарт буй айл өрхийн газар болон хөрөнгийн үнэлгээг АХБ-ны Хамгааллын бодлогын дагуу хөндлөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага болох “Бэсгэ” ХХК-иар Баянхошуу дэд төвд, “Тэгш сонголт эстимэйт” ХХК-иар Сэлбэ дэд төвд тус тус гүйцэтгүүлэн үнэлгээний тайланг монгол, англи хэлээр, мөн нэгж талбар бүрээр гаргуулан авч НГА-д хүлээлгэн өгсөн. Мөн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулах ажил 85%-ийн явцтай буюу АХБ-аар батлуулах шатанд явж байна. Уг төлөвлөгөөг АХБ-аар батлуулахад банкны тавьж буй шаардлагын дагуу газар чөлөөлөлтөд өртөж буй нэгж талбарт амьдарч байгаа газаргүй иргэдэд шинээр газар олгох асуудлыг шийдвэрлэх шаардлага үүссэн.

Түүнчлэн, 2017 оны 10 дугаар сараас эхлэн 2 дэд төвд нөлөөлөлд өртсөн иргэдтэй ойр ажиллах, аль болох чирэгдэлгүй үйлчлэх зорилгоор дэд төвүүдэд оффис шинээр тохижуулан НГА, үнэлгээний мэргэжлийн байгууллагын зөвлөх, ТХН-ийн ажилтнуудын баг тогтмол байрлан иргэд болон хороодын Оршин суугчдын зөвлөл, Бизнесийн зөвлөлийн бүлгийн болон холбогдох төрийн бус байгууллагын төлөөлөл оролцуулан уулзалтууд зохион байгуулав.

Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нийт трассын дагуу газар чөлөөлөлтийн хязгаарыг газар дээр шугам тавьж тэмдэглэх ажлыг мэргэжлийн байгууллага “Голден Лайн” ХХК компани 2017 оны 12 дугаар сард бүрэн хийж дуусгав.

Тайлангийн хугацаанд газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажилтай холбоотой гомдол, санал бүхий өргөдлийг иргэдээс хүлээн авч тухай бүрт нь шийдвэрлэн хариу өгч ажиллалаа.



Нүүлгэн шилжүүлэлтийн явц



Баянхошуу дэд төв дэх газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн дараах цэвэрлэгээний ажил



Баянхошуу дэд төв дэх газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц

Нийслэлийн шинэ өнгө төрхийг илтгэх Хотын дэд төвийн бүтээн байгуулалтыг дэмжиж, газраа чөлөөлсөн иргэддээ талархал илэрхийлж байна.


ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТ, НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ЯВЦ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКТАЙ САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛСНААР МУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР УЛААНБААТАР ХОТТОЙ ДАМЖУУЛАН ЗЭЭЛДЭХ ГЭРЭЭ ХИЙСЭН. УГ ГЭРЭЭНИЙ ДАГУУ НИЙСЛЭЛ ГЧНШ-ИЙН ЗАРДЛЫГ БҮРЭН ХАРИУЦАХ ҮҮРГИЙГ ХҮЛЭЭСЭН.

ГАЗРЫН ҮНЭЛГЭЭГ

ЗӨВШӨӨРСНИЙ ДАРАА:

2018 оны 1-р сарын байдлаар хоёр дэд төвүүдэд нийт 700 айлтай зөвшилцөх ажлын явц 70,43% -тай байна. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг 2018 оны 4-р сард бүрэн дуусгаж барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.



- НИЙСЛЭЛИЙН ГАЗРЫН АЛБАНЫ ДОТООД САНАЛ
- НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ ГАРАХ ЯВЦ
- ЗАХИРАМЖ ГАРСНААР ГАЗРЫН АЛБА ИРГЭДТЭЙ ГЭРЭЭ БАЙГУУЛЖ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ

НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХДОО:

**100% ОЛГОХ
ГАЗРАА БҮРЭН
ЧӨЛӨӨЛСӨН**


**УРЬДЧИЛГАА 60% ОЛГОХ
ГАЗРАА ЧӨЛӨӨЛСНИЙ ДАРАА
+ 40%**

**ГАЗАР БОЛОН ЭД ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭГ БИЕ ДААСАН
ХАРААТ БУС ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИ ХИЙНЭ.**

Иргэдтэй үнийн дүн зөвшилцсөнөөс хойш иргэдэд нөхөн олговор олгох хүртэл нийт 14 үе шат дамжиж, дунджаар 3.2 сар зарцуулж захирамж гардаг. Төслийн газар чөлөөлөлтийн ажлыг хурдасгаж цаг хугацаанд нь хийх зорилгоор төслийн нэгжээс захирамж гарах 14 шатлалыг 8 болгон цөөрүүлэх, 3.2 сарыг 14 хоног болгож бууруулах санал бүхий албан бичгийг НЗДТГ-т хүргүүлээд байна.

ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТИЙН ЯВЦ

2017 ОН



2017 ОНЫ ЭЦЭС ХҮРТЭЛХ БОЛОН 2018 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2017 оны эцэст төслийн гүйцэтгэлийн явцыг 40%-д хүргэхээр төлөвлөсөн ба үүнд төслийн худалдан авах ажиллагаа, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажиллагааг 90%-д хүргэхээр төлөвлөн ажиллаж байна. Мөн барилга угсралтын бэлтгэл ажлыг ханган гүйцэтгэгчидтэй гэрээ байгуулах, техник технологийн шийдлүүдийг гарган, шаардлагатай бараа материалын таталт хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

2018 оны төслийн гүйцэтгэлийн явцыг 80%-д хүргэх ба үүнд дараах гэрээт ажлуудыг 100% гүйцэтгэн, ашиглагч байгууллагуудад хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн. Үүнд:

- Дулааны шугамын өргөтгөлийн барилга
- Баянхошуу дэд төвд баригдах 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга
- Баянхошуу дэд төвд баригдах бизнес инкубатор болон МСҮТ-ийн барилга
- Сэлбэ дэд төвд баригдах 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга
- Сэлбэ дэд төвд баригдах бизнес инкубатор болон МСҮТ-ийн барилга
- Сэлбэ дэд төвд баригдах 3 гүүрний барилга угсралтын ажил
- Баянхошуу дэд төвд баригдах цахилгаан, холбооны шугам сүлжээ, дэд станцын барилга
- Сэлбэ дэд төвд баригдах цахилгаан, холбооны шугам сүлжээ, дэд станцын барилга
- Орлогод нийцсэн орон сууц, хот шинэчлэлтийн төслийн туршилтын төслийн барилга
- Төв цэвэрлэх байгууламжийн шинэчлэлт, дугуй резервуарын засварын ажил
- Баянхошуу, Сэлбэ дэд төвд баригдах үерийн далан, хамгаалалтын сувгийн барилга
- УСҮГ-ын үйл ажиллагааг сайжруулах дэд төсөл
- Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн ус, бохирын шугам хоолойн ханган нийлүүлэх ажил

Дараах ажлуудын 2018 оны гүйцэтгэлийг 90% хүртэл хувьд хүргэж 2019 онд бүрэн дуусган ашиглагч байгууллагуудад хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн. Үүнд:

- Улаанбаатар хотын зүүн хойд бүсийн усан сангаас Тасганы усан сан хүртэлх HDPE ф900мм-ийн 4010 метр урт цэвэр ус дамжуулах гол шугамын болон ф600мм-ийн 1684.23 метр урт “9Б” бохир ус зайлуулах зөөлөн ширмэн яндан хоолой шугамын барилга
- Улаанбаатар хотын Тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан, баруун дүүргийн насос станц хүртэлх 7054 метр урттай ф600мм-ийн цэвэр ус дамжуулах гол шугамын барилга
- Улаанбаатар хотын Орос 14-р сургууль орчмын барилга байгууламжийн бохирын татуургын гол цуглуулах шугам /543 метр урттай ф400мм-ийн ОКП146100 резинэн жийргэвчтэй ширмэн хоолой/-ын барилга угсралтын ажил
- Баянхошуу, Сэлбэ дэд төвийн гадна тохижилтын ажил
- Баянхошуу, Сэлбэ дэд төвд баригдах усан сангийн барилга
- Баянхошуу дэд төвд баригдах авто зам, дулааны болон бусад инженерийн шугам сүлжээний барилга
- Сэлбэ дэд төвд баригдах авто зам, дулааны болон бусад инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил
- Сэлбэ дэд төвд баригдах дулаан цахилгаан станц
- Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд баригдах инженерийн шугам сүлжээний салбар шугамын холболтын ажил (магистраль шугам сүлжээний ажлуудын дараа хийгдэх ажил).

Дээрх ажлуудын зэрэгцээ 2018 онд Төсөл 2-ийн хүрээнд хийгдэх ажлуудын нарийвчилсан зураг төслүүдийг эцэслэн боловсруулж, худалдан авах, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг эхлүүлэн гүйцэтгэлийн явцыг 30%-д хүргэх, Төсөл 3-ын ТЭЗҮ-г эцэслэн боловсруулж дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

ТӨСЛИЙН 1-Р ҮЕ ШАТАНД ХИЙГДЭХ ДЭД БҮТЦИЙН АЖЛУУД

2017 ОНД ХИЙСЭН АЖИЛ

/НАСОС, АРИУТГАХ ТАТУУРГА/

ҮЙЛДВЭРИЙН НАСОС СТАНЦЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ШИНЭЧЛЭН САЙЖРУУЛАХ ДЭД ТӨСӨЛ

“Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн хүрээнд УСУГ-т нэгдсэн удирдлагын СКАДА систем байгуулж усны алдагдлыг илрүүлэх зэргээр үйл ажиллагааны горимыг сайжруулж, ус, эрчим хүчний хэмнэлт үүсгэн ашиглалтын зардлыг бууруулав.

Тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн хүрээнд Үйлдвэрийн насос станцад 1 өргөгчийн насос станцын гүний худгийн 16 ширхэг насосыг иж бүрнээр нь шинэчлэн суурилуулж, ашиглалтад оруулав. Мөн Төвийн насос станцын эх үүсвэрийн 2 өргөгчийн 4 насос, 6 кВ-ын давтамж хувиргагчийг барилгын хамт барьж ашиглалтад оруулан УСУГ-т 2017 оны 11 сарын 8-нд хүлээлгэн өгсөн.




Тоног төхөөрөмжийн шинэчлэлийн үр дүнд хэрэглээнд суурилсан насосын ажиллагаатай болж цахилгаан эрчим хүчийг **15-30 хувь**, цэвэр усыг **5-10 хувь** хэмнэх тооцоо гарсан байна.



БАЯНХОШУУ ДЭД ТӨВИЙН АРИУТГАХ ТАТУУРГЫН АЖИЛ

Баянхошуу, Сэлбэ дэд төвд баригдах бохирын гол коллектор шугамын барилга угсралтын ажлыг гүйцэтгэн Улсын комисст хүлээлгэн өгөв. /Нийт 8,6 км/



2018 ОНД ХИЙГДЭХ АЖЛУУД

/ЦЭЦЭРЛЭГ, МСУТ, ДУЛААНЫ СТАНЦ/

ДЭД БҮТЭЦ

Баянхошуу дэд төвд 6,57км авто зам, 2,4км үерийн хамгаалалт, 6,71км цэвэр усны шугам, 13,8км бохир усны шугам, 4,8км дулааны шугамын ажил, Сэлбэ дэд төвд 5,8 км авто зам, 2,3 км үерийн хамгаалалт, 11,9 км цэвэр усны шугам, 12,51км бохир усны шугам, 1,3 км дулааны шугамын ажлыг тус тус 2018 онд эхлүүлнэ.

ЦЭЦЭРЛЭГ

Төслийн нэгдүгээр шатны хүрээнд Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдэд тус бүр 240 хүүхдийн цэцэрлэг байгуулна. Цэцэрлэг ашиглалтад орсноор хоёр дэд төв дэх цэцэрлэгийн насны нийт 480 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах боломж бүрдэнэ.

БИЗНЕС ИНКУБАТОР-МСУТ

Сургалтын болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай талбай бүхий хоёр давхар Бизнес инкубатор - МСУТ-ийн барилга ашиглалтад орсноор дэд төвд мэргэжил олгож, бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх боломжтой болно.

ДУЛААНЫ СТАНЦ

Сэлбэ дэд төвийн хүрээнд Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт 158 га талбайг хамарна. Уг дэд төвд 26,68 Мвт хүчин чадал бүхий олон улсын стандартад нийцсэн дулааны станц, дулааны шугамыг барьж байгуулна. Ойрын жилүүдэд хийгдэж байгаагүй энэхүү томоохон бүтээн байгуулалт баригдсанаар 6,000 орчим өрхийн 25,400 иргэн инженерийн шугамд холбогдон, төвийн дулаанаар хангагдана. Түүнчлэн, тус дэд төвийн иргэд хамтран хувийн сууцны төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах, харьцангуй хямд үнээр орон сууцтай болох боломжтой.



ГЭР ХОРООЛЛЫГ ОРОН СУУЦЖУУЛАХ БОДЛОГО ХӨТӨЛБӨРҮҮД

ЭДЭЛБЭР ГАЗАР БҮХИЙ ОРОН СУУЦНЫ ХОРООЛЛЫГ **ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ**



● ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

- ДЭД БҮТЦЭД ХОЛБОГДСОН АМИНЫ ОРОН СУУЦЫГ ИПОТЕКИЙН ЗЭЭЛД ХАМРУУЛАХ НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛЭХ:
ИРГЭН ИПОТЕКИЙН ЗЭЭЛД ХАМРАГДАН БАЙШИНГАА САЙЖРУУЛЖ ДЭД БҮТЦЭД ХОЛБОГДСОН ЭКО ХАУСТАЙ БОЛОХ БОЛОЛЦООГ ЭРЭЛХИЙЛНЭ.
ИРГЭН ӨӨРӨӨ АМЬДРАХ ОРЧИН НӨХЦЛӨӨ САЙЖРУУЛАХ БОЛОМЖТОЙ БОЛНО.

● ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦ

- ОРЛОГОД НИЙЦСЭН ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦ
- ТҮРЭЭСЛЭЭД ӨМЧЛӨХ:
БАГА ОРЛОГОТОЙ ИРГЭД ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦАНД ОРЖ САР БҮРИЙН ТӨЛӨЛТ ТУХАЙН БАЙРНЫ ҮНИЙН ДҮНГИЙН 30 ХУВЬД ХҮРСНИЙ ДАРАА ҮЛДСЭН 70 ХУВИЙГ 20-30 ЖИЛИЙН ХУГАЦААТАЙ ИПОТЕКИЙН ЗЭЭЛД ХАМРУУЛАХ НӨХЦЛИЙГ СУДАЛЖ БАЙНА.
ЭНЭХҮҮ АЖИЛ ТҮРЭЭСНИЙ ОРОН СУУЦНЫ БОДЛОГО ЖУРМААР ЗОХИЦУУЛАГДАНА.

● ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН СУУЦ

- ХУДАЛДАН АВАХ БОЛОМЖ ЧАДВАРТ НИЙЦСЭН БҮХИЙ ОРОН СУУЦ
- ДУЛААНЫ АЛДАГДАЛГҮЙ ТЕХНОЛОГИ
- ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ (СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ АШИГЛАХ)
- АШИГЛАЛТЫН ЗАРДАЛ БАГА
- ЭКО НОГОО ОРЧИН БҮРДҮҮЛЭХИЙГ ЗОРИНО

ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН СУУЦ



Улаанбаатар хотын дэд төвүүдэд иргэдийн газрыг орон сууцаар шууд солих нөхцөлтэй 10 мянган ногоон орон сууц төслийг Нийслэлийн Засаг даргын тамгын газар хариуцан, Азийн хөгжлийн банк санхүүжүүлэн хэрэгжүүлнэ. Энэ бүтээн байгуулалтын дэд бүтцийг хангах нь “Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн нэг зорилго юм. Төслийн үр нөлөөг 100 мянган өрх шууд хүртэнэ. Улаанбаатар хотын хөрс, агаарын бохирдол, ногоон байгууламж, инженерийн дэд бүтэц зэрэг тулгамдсан асуудлууд бүрэн шийдэгдэж, хүн ардын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрэн хангагдана.

Дэд төвүүдийг хөгжүүлэх чиглэлээр зарим яам, тамгын газар, Улсын бүртгэлийн газар гэх мэт төрийн байгууллагууд, мөн Байгалийн түүхийн музей, их, дээд сургуулиуд, дүүргийн 1 цэгийн үйлчилгээг нүүлгэн шилжүүлж, дэд төвүүдэд төвлөрүүлэх боломжтой юм.


ХОЛИМОГ ОРОН СУУЦНЫ БОДЛОГО /НОСК, ТОСК/

D

Янз бүрийн орлоготой иргэдийн төлбөрийн чадварыг бодолцолгүй орон сууцаар хангах бодлогуудыг төлөвлөдгөөс орлого багатай иргэдийн орон сууцны асуудлыг шийдэж чадаагүй хэвээр байна.


D

Янз бүрийн орлоготой иргэдийн ашиг орлогын түвшинд тохирсон сонголтууд бүхий сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлэх



ДЭД БҮТЦИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХИЙН ТУЛД ДЭД ТӨВИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО, АРГА МЕХАНИЗМ

ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ, БЛОК ТӨЛӨВЛӨЛТ ГЭЖ ЮУ ВЭ



НЭГ БЛОК = НЭГ ХОРООЛОЛ

ТӨР болон **ГАЗРЫН ЭЗДИЙН**
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НӨХЦӨЛ:

Блок гэж юу вэ?

Авто зам, газрын гадаргын нөхцөл байдлын онцлогоор тусгаарлагдсан тодорхой хэсэг газрыг блок гэнэ.



ТАВИГДАХ НӨХЦӨЛ:

ТӨЛБӨРИЙГ МӨНГӨӨР БОЛОН
ГАЗРААР ХИЙХ БОЛОМЖТОЙ
ӨМЧИЙН болон ЭЗЭМШЛИЙН
ГАЗРЫН 30 -35 хувийн
газраар дэд бүтцийн
төлбөрийг хийх боломжтой.

ДЭД ТӨВИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, МЕХАНИЗМ

ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ, УЯН ХАТАН, ТОГТВОРТОЙ ХӨГЖИХ, ХҮРТЭЭМЖТЭЙ ДЭД ТӨВ БОЛНО

Нийгмийн хангамжийн
хүртээмжтэй, олон
нийтийн газартай
ажиллаж амьдрахад
тухтай төв

Өөрийн гэсэн өнгө
төрхтэй, ажлын байртай,
эдийн засгийн идэвхтэй
төв

Төрөл бүрийн худалдан
авагчдын эрэлтэд
нийцсэн орон сууцны
хорооллуудтай төв

ХОТ ТӨЛӨВЛӨЛ ХОТЫН ШИНЭЧЛЭЛ

ГЭР ХОРООЛЛЫН ГАЗРЫГ
ШИНЭЧЛЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ГЭР ХОРООЛЛЫГ ДАХИН
ТӨЛӨВЛӨЖ БАРИЛГАЖУУЛАХ

**ХОТЫГ ШИНЭЧЛЭХ 3 ТӨРЛИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД ТӨЛӨВЛӨЛТИЙН БЛОКУУДЫГ
ГАЗРЫН ЭЗЭДТЭЙ ХАМТРАН ХӨГЖҮҮЛЭХЭЭР АЖИЛЛАНА.**



ЭНГИЙН САЙЖРУУЛАХ

БАГА НЯГТРАЛТАЙ ОРОН СУУЦНЫ БЛОКУУДЫГ
ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ




ЦОГЦООР САЙЖРУУЛАХ

ДУНД НЯГТРАЛТАЙ ХОЛИМОГ АШИГЛАЛТАЙ
БЛОКУУДЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ




ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ

ӨНДӨР НЯГТРАЛТАЙ ХОЛИМОГ АШИГЛАЛТАЙ
БЛОКУУДЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ



ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ, БЛОК ТӨЛӨВЛӨЛТ

Үзүүлэлт			В-5 блок	Дэд блок	Эдэлбэр газрын тоо
Байнгын оршин суугчид	Гэрт	Тоо	75	В-5-1	23
		Өрхийн тоо	78	В-5-2	33
		Хүн амын тоо	284	В-5-3	21
	Байшинд	Тоо	309	В-5-4	20
		Өрхийн тоо	276	В-5-5	32
		Хүн амын тоо	1084	В-5-6	14
Түрээсийн оршин суугчид	Газар	Өрхийн тоо	7	В-5-7	24
		Хүн амын тоо	18	В-5-8	34
	Хажуу өрөө	Өрхийн тоо	2	В-5-9	13
		Хүн амын тоо	5	В-5-10	34
	Байшин	Өрхийн тоо	2		
		Хүн амын тоо	5		



ТАНИХ ТЭМДЭГ:

- Төлөвлөлтийн хил
- Кадастрын зураг
- Газрын хэвгий
- Батлагдсан авто зам /Баянхошуу нэгж/
- Төлөвлөж буй авто зам

ГАЗАР АШИГЛАЛТ, ҮҮРГИЙН БҮСЧЛЭЛ:

- Худалдаа үйлчилгээний халимгос бүс-2
- Худалдаа үйлчилгээний халимгос бүс-1
- Амьны орон сууцны халимгос бүс - АОСХБ-1
- Төрийн үйлчилгээний бүс /Суурь, цэцэрлэг/
- Ногоон байгууламж, олон нийтийн бүс

СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ:

- Төлөвлөж буй сургууль
- Одоо байгаа цэцэрлэг

ТЭМДЭГЛЭГЭЭ:

- Блокын дугаар
- Блокын нэр
- Натурал хуви
- Давхрын тоо
- Блокын талбай
- Барилгын талбайн Коэффициент

БЛОК НЬ ГУДАМЖ, ХОРООЛОЛ ДОТОРХ ЗАМУУДААР ДЭД БЛОКД ХУВААГДАЖ БОЛНО. ДЭД БЛОК ТУС БҮРЭЭР ТӨЛӨВЛӨЛТИЙГ ОРШИН СУУГЧДЫН ОРОЛЦООТОЙГООР ХИЙХ БОЛОМЖТОЙ.



**АЯ ТУХТАЙ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС**

Дэд төвд оршин сууж буй иргэд, газрын эзэд, бизнес эрхлэгчдийн ажиллаж амьдрах нөхцлийг сайжруулж, хувийн орон сууц, барилга байгууламж салбарлан барих санал санаачилгыг нь дэмжих нийтийн зориулалттай үйлчилгээг өргөтгөн, нэг төвт хотоос олон төвт хот болж нийслэлийн иргэдийн өмнө тулгарсан түгжрэл, хэт төвлөрлийг сааруулж, Үлэг гүрвэлийн музей, аялал жуулчлалын бүсийг цогцлоон байгуулж, ая тухтай, орчин үеийн стандарт бүхий орон сууцны хорооллыг сүндэрлүүлэхэд чиглэнэ.

БНСУ-ын засгийн газраас 55.0 сая ам.доллараар санхүүжүүлэн барих байгалийн түүхийн музей, паленталогийн хүрээлэнг Сэлбэ дэд төвд барьснаар, Дамбадаржаа хийдтэй хоршсон аялал жуулчлалын цогц бүтээгдэхүүн бий болох боломжтой.

**ДЭД ТӨВҮҮДЭД
НИЙГМИЙН
ХАНГАМЖИЙН
ТОМООХОН
БАЙГУУЛАМЖУУД БИЙ
БОЛОХ БОЛОМЖ**

	Төрийн үйлчилгээний байгууллагууд	Дэд төв рүү нүүлгэн шилжүүлэх	Шинээр/салбар байгуулах
1	Зарим яам, тамгын газар	✓	
2	Улсын бүртгэлийн газар	✓	
3	Шинэ Дүүрэг байгуулах		✓
4	Нийслэлийн зарим агентлагууд	✓	
5	Мэргэжлийн хяналтын газар	✓	✓
6	Архивын газар	✓	
7	Геологи палеонтологийн хүрээлэн	✓	✓
8	Байгалийн түүхийн музей	✓	
9	Их, дээд сургуулиуд	✓	
10	Дүүргийн 1 цэгийн үйлчилгээ		✓
11	Усан спортын ордон		✓
12	Монголын гимнастикийн ордон		✓



**ДЭНЖИЙН МЯНГА, ДАМБАДАРЖАА:
ТӨСЛИЙН 2 ДУГААР ҮЕ ШАТНЫ БЭЛТГЭЛ БА
ТӨСЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА**

Хөтөлбөр нь АХБ-ны олон шатлалт санхүүжилттэй бөгөөд хөтөлбөрийн 2 дугаар үе шатны ТЭЗҮ боловсруулах ажил 1 дүгээр үе шатанд хийгдэн, зээлийн гэрээ байгуулах замаар хөтөлбөрийн үе шатууд тодорхой хугацаанд давхцан харилцан уялдаатай байхаар төлөвлөгдсөн. Үүний дагуу төслийн нарийвчилсан зураг төслийн баг Төсөл 2-ийн ТЭЗҮ-г боловсруулан 2017 оны 02 дугаар сард ТХН-ид хүлээлгэн өгсөн. Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн дагуу Төслийн 2-р үе шатны нийт санхүүжүүлэлт 121.1 сая ам.доллар ба үүний 66.35 сая буюу 54.78%-ийг АХБ, 19.64 сая буюу 16.21%-ийг ЕХОБ, 35.15 сая буюу 29.02%-ийг Нийслэлийн төсвөөс санхүүжүүлнэ.

Төслийн 2-р үе шат нь 2016 оны 12 дугаар сард шинэчилсэн АХБ-ны Зээлийн удирдлагын баримт бичигт заасны дагуу 2 багц зөвлөх үйлчилгээтэй байна. Тайлангийн хугацаанд ТХН-ийн ХШҮ-ний мэргэжилтнээр удирдуулсан төслийн инженер, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн мэргэжилтэн, байгаль орчин, нийгмийн хамгааллын мэргэжилтнүүдээс бүрдсэн баг нарийвчилсан зураг төсөл боловсруулах, барилгын хяналтын зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулж, АХБ-аас зөвшөөрөл аван АХБ-ны цахим системээр олон улсын нээлттэй зөвлөхийн тендерийг 2017 оны 08 дугаар сарын 22-ны өдөр зарлан, оролцох сонирхол илэрхийлсэн хүсэлтийг дагалдах материалын

хамт 09 дүгээр сарын 22-ны өдөр хүлээн авсан. Нийт 15 компани материалаа ирүүлсэн.

Мөн Төсөл 2-ийн Байгууллагын чадавхи бэхжүүлэх, менежментийн дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний 5 бүрэлдэхүүн хэсэг бүхий ажлын даалгаврыг эцэслэн боловсруулж, АХБ-аас зөвшөөрөл аван тус цахим системээр 2017 оны 08 дугаар сарын 23-ны өдөр нээлттэй зарласан. Тус зөвлөхийн сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ ирүүлсэн нийт 18 компани байна. Зөвлөхийн санал авах сүүлийн хугацаа 09 дүгээр сарын 22-ны өдөр байв. Дээрх 2 зөвлөх үйлчилгээний дараагийн шатны сонгон шалгаруулалтын бичиг баримтыг боловсруулах ажлыг эхлүүлээд байна.

Төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, мөн Төсөл 2-ийг эхлүүлэхтэй холбоотойгоор төслийн зохицуулагчийн санаачилгаар төслийн үйл ажиллагааны схем гаргаж, ажлын онцлог, уялдаа холбоонд тулгуурлан багуудад хуваах, багийн зохион байгуулалтаар ажиллах, ажилтнуудын гүйцэтгэлийг ажлын үр дүн, цаг ашиглалт, ажлын ачаалал зэргийг тооцон сараар үнэлэх системийг 2017 оны 08 дугаар сарын дундаас туршилтын журмаар хэрэгжүүлж эхлээд байна. Төслийн менежментийн арга барилаар багийн зохион байгуулалтад оруулж, ажлын ачааллыг багуудад хуваарилан харилцан уялдаатай ажиллах боломж бүрдүүлснээр төслийн худалдан авах болон газар чөлөөлөх ажиллагааг эрчимжүүлж тодорхой үр дүнд хүрээд байна.



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

**ТӨСЛИЙН 2-Р ҮЕ ШАТ
ДЭНЖИЙН МЯНГА
ДАМБАДАРЖАА**

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦОО ДЭМЖЛЭГ



Азийн Хөгжлийн Банкны Зүүн Азийн бүс хариуцсан ерөнхий захирал ноён Аюми Кониши 2017 оны 1 дүгээр сард Монгол Улсад ажлын айлчлал хийлээ. Ажлын айлчлалаар "Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн хэрэгжилтийн явц болон "Орлогод нийцсэн орон сууц ба хотын шинэчлэл" төслийн бэлтгэл ажилтай танилцлаа.



"Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн хэрэгжилтийн явцад үнэлэлт дүгнэлт өгөхөөр АХБ-ны хяналт-шинжилгээ, үнэлгээний дунд хугацааны баг манай улсад 2017 оны 2-р сарын 14-ний өдөр хүрэлцэн ирлээ



"Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн багийнхан НИТХ-ын төлөөлөгчдөд төслийн явцын талаарх танилцуулах уулзалтыг 2017 оны 5-р сарын 02-ны өдөр хийлээ



Агаарын бохирдлыг бууруулах ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Ё.Баатарбилэг, УИХ-ын гишүүн Д.Тэрбишдагва, Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Барилга, хот байгуулалтын яам, Эрчим хүчний яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох албаны хүмүүс агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж буй төслийн явцтай танилцлаа.



Азийн Хөгжлийн Банкны дэд захирал Мухаммэд Сами Сاعد, Азийн Хөгжлийн Банкны Эдийн засаг стратеги төлөвлөлтийн газрын Монгол дахь суурин төлөөлөгч Деклан Магээ болон хот төлөвлөлтийн мэргэжилтэн Арнауд Хекманэ нар "Сэлбэ" дэд төв дээр баригдсан 50 айлын орон сууцаар зочиллоо.



АХБ-ны удирдах зөвлөлийн захирлууд манай улсад 2017 оны 5-р сард ажлын айлчлал хийлээ. Тэд төслийн багийнхантай уулзаж, төсөл хэрэгжих талбайгаар явж нөхцөл байдалтай танилцав.



Төслийн явцтай Эрүүл мэндийн сайд Ц.Сарангэрэл, УИХ-ын гишүүн Д.Тэрбишдагва, Б.Бат-Эрдэнэ, нар 2018 оны 1 сарын 10-нд танилцлаа



"Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн багийнхан 2017 оны 8-р сарын 03-ны өдөр иргэдтэй уулзаж, иргэд төслийн үр дүнг хүртэхэд хэрхэн оролцож болох болон энэ нь Улаанбаатар хотын нийт иргэдэд ямар ач холбогдолтой болох талаар дэлгэрэнгүй тайлбарлан, санал бодлоо чөлөөтэй солилцлоо



"Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслөөс дэд төвийн хороод буюу Сүхбаатар дүүргийн 14, 13, Чингэлтэй дүүргийн 14, 18 болон Сонгино Хайрхан дүүргийн 7, 8, 9, 10 дугаар хороодын ажилчдад төслийн нэгдүгээр шатны ажлын явцыг танилцуулах уулзалтыг 2017 оны 10-р дугаар сарын 5, 6-ны өдөр Сэлбэ болон Баянхошуу төвүүдэд тус тус зохион байгуулсан юм. Үр дүнд иргэд төслийн ажлын явцын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч, бүтээн байгуулалтад оролцон, хамтран ашигтай ажиллахдаа таатай байгаагаа илэрхийллээ.



Нийслэлийн Инновацийн газартай хамтран ажиллахаар болов



"Сэлбэ" дэд төвд 26.68Мвт хүчин чадал бүхий олон улсын стандартад нийцсэн дулааны станц, дулааны шугамыг барихаар төлөвлөн олон улсын нээлттэй тендер зарлахад "Хүрд" ХХК болон БНХАУ-ын "Шиншианг Гонгшэн Бойлер" ХХК түншлэл шалгарсан. Уг дулааны станц болон дулааны шугамын ажил хийгдсэнээр инженерийн шугамд 6,000 орчим өрхийн 25,400 иргэн хамрагдан гэр хорооллын нүүрсний хэрэглээ 15 мянган тонноор буурна.



Тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн хүрээнд Үйлдвэрийн насос станцад 1 өргөгчийн насос станцын гүний худгийн 16 ширхэг насосыг иж бүрнээр нь шинэчлэн суурилуулж, ашиглалтад оруулав. Мөн Төвийн насос станцын эх үүсвэрийн 2 өргөгчийн 4 насос, 6 кВ-ын давтамж хувиргагчийг барилгын хамт барьж ашиглалтад оруулан УСҮГТ 2017 оны 11 сарын 8-нд хүлээлгэн өглөө



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо Бага тойруу 1,
Амарын гудамж-2 Соёлын төв өргөө, Г-корпус-415

Утас: 7000-3099

Факс: 7000-3098

Баянхошуу, Сэлбэ дэд төв: 7500-3099

www.ub-subcenter.mn